



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/79/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: К.Риза

Утас: 94156768

Цахим хаяг: Kalim_riza@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

САГСАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА А.ШЕПЕН
ТАНАА

2022.02.25 № 239
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48053333.00</u>	<u>44773855.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	48053333.00	44773780.00
354	Хангамжийн материал	24533333.00	21253780.00
35410	Бичиг хэргийн материал	266500.00	175000.00
35420	Аж ахуйн материал	24266833.00	20848780.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	230000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
35600	Мал амьтад	23520000.00	23520000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1299314445.28</u>	<u>3358091087.83</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1299314445.28	3358091087.83
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	1264476445.28	3323253087.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	317494550.00	601111886.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29244560.16	-38260530.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	195868293.00	201568293.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-76669285.13	-95684243.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106183933.00	107333933.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80228788.71	-88425730.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67661193.62	76446473.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46120102.67	-50465055.32
39209	Зам, гүүрийн байгууламж	70176080.00	1921811378.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-47338868.82	-64084574.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	901673458.00	901673458.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-114979456.85	-149772199.65
393	Биет бус хөрөнгө	34838000.00	34838000.00
39301	Програм хангамж	2013400.00	2013400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2013400.00	-2013400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34838000.00	34838000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1347367778.28</u>	<u>3402864942.83</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>14133506.18</u>	<u>4537321.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14133506.18	4537321.00
413	Өглөг	14133506.18	4537321.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3128825.18	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11004681.00	4537321.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1333234272.10</u>	<u>3398327621.83</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1333234272.10	3398327621.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	493918878.07	493918878.07
51101	Өмч: - төрийн	493918878.07	493918878.07
512	Хуримтлагдсан үр дүн	-559600068.55	1505493281.18
51210	Өмнөх үеийн үр дүн	-536996839.85	-559600068.55

51220	Тайлант үеийн үр дүн	-22603228.70	2065093349.73
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1398915462.58	1398915462.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1347367778.28	3402864942.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	442,389,584.00	2,516,142,168.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	83,005,045.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	359,384,539.00	2,516,142,168.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,851,635,298.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	1,851,635,298.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,605,939.00	5,701,154.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,700,939.00	3,101,154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,905,000.00	2,600,000.00
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	346,778,600.00	658,805,716.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	346,778,600.00	360,703,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	298,102,616.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	464,992,812.70	451,048,818.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	464,992,812.70	451,048,818.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	451,663,773.20	451,048,818.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,533,033.68	251,042,741.82
210101	Үндсэн цалин	238,418,923.28	231,448,745.82
210102	Нэмэгдэл	3,163,015.40	3,549,896.00
210104	Урамшуулал	888,620.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	5,062,475.00	16,044,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,867,000.00	32,550,759.00
210201	Тэтгэврийн даатгал	23,128,600.00	22,851,259.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,434,600.00	2,424,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,947,700.00	1,939,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	486,900.00	484,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,869,200.00	4,849,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,844,000.00	14,406,178.00
210301	Гэрэл, цахилгаан	2,850,700.00	814,726.00
210302	Түлш, халаалт	11,993,300.00	13,591,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,979,498.00	21,037,804.00
210401	Бичиг хэрэг	3,453,300.00	2,054,335.00
210402	Тээвэр, шатахуун	17,407,818.00	17,622,869.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,118,380.00	1,092,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	268,300.00
2105	Нормативт зардал	1,704,700.00	598,800.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,704,700.00	598,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,915,700.00	6,532,600.00
210604	Урсгал засвар	4,915,700.00	6,532,600.00
2107	Томилолт, зочны зардал	4,157,000.00	1,220,142.00
210702	Дотоод албан томилолт	4,157,000.00	1,220,142.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,844,384.00	1,083,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	398,284.00	234,920.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	427,600.00	302,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,900.00	124,780.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95,600.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	459,900.00	276,600.00
210807	Газрын төлбөр	43,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	93,800.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,818,457.52	122,575,993.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,495,850.00	29,969,722.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	495,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,322,607.52	92,111,271.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,329,039.50	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,329,039.50	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,329,039.50	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(22,603,228.70)	2,065,093,349.73
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(22,603,228.70)	2,065,093,349.73

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	493,918,878.07	1,398,915,462.58	-559,600,068.55	1,333,234,272.10
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	493,918,878.07	1,398,915,462.58	-559,600,068.55	1,333,234,272.10
D08	Тайлант үеийн үр дүн			2,065,093,349.73	2,065,093,349.73
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	493,918,878.07	1,398,915,462.58	1,505,493,281.18	3,398,327,621.83

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	359384539.00	366404254.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	359384539.00	366404254.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12605939.00	5701154.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9700939.00	3101154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2905000.00	2600000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	346778600.00	360703100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	346778600.00	360703100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	359384539.00	365254179.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	359384539.00	365254179.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346055499.50	365254179.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	258987671.50	253930700.00
210101	Үндсэн цалин	162150500.00	195865600.00
210102	Нэмэгдэл	53965029.40	42021000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49628.00	
210104	Урамшуулал	1219161.00	
210105	Гэрээт ажлын хөлс	41603353.10	16044100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32867000.00	32835768.00
210201	Тэтгэврийн даатгал	23128600.00	23136268.00
210202	Тэтгэмжийн даатгал	2434600.00	2424900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1947700.00	1939900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	486900.00	484900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4869200.00	4849800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14844000.00	14816125.00
210301	Гэрэл, цахилгаан	1248218.00	1224673.00
210302	Түлш, халаалт	13595782.00	13591452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21539428.00	19031429.00
210401	Бичиг хэрэг	3210600.00	2032000.00
210402	Тээвэр, шатахуун	16210448.00	16010529.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2118380.00	900900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		88000.00
2105	Нормативт зардал	458300.00	462000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	458300.00	462000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15600.00	5385600.00
210604	Урсгал засвар	15600.00	5385600.00
2107	Томилолт, зочны зардал	2500600.00	1875300.00
210702	Дотоод албан томилолт	2500600.00	1875300.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1784900.00	1286800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	318000.00	150400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	427600.00	302200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108300.00	90300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217900.00	182900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95600.00	75000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478100.00	379700.00
210807	Газрын төлбөр	45600.00	37300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	93800.00	69000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13058000.00	35630457.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13058000.00	35130457.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		500000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13329039.50	0.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13329039.50	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	1150075.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	1150000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	1150000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	1150000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		1150000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-1150000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	75.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		75.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343822100.00	333449560.50	360703100.00	360703025.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343822100.00	333449560.50	360703100.00	360703025.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343822100.00	333449560.50	360703100.00	360703025.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265259500.00	257252160.50	253930700.00	253930700.00
210101	Үндсэн цалин	165867200.00	161606500.00	195865600.00	195865600.00
210102	Нэмэгдэл	56807300.00	53965029.40	42021000.00	42021000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		49628.00		
210104	Урамшуулал		27650.00		
210105	Гэрээт ажлын хөлс	42585000.00	41603353.10	16044100.00	16044100.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32867000.00	32867000.00	32736200.00	32736200.00
210201	Тэтгэврийн даатгал	23128600.00	23128600.00	23036700.00	23036700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2434600.00	2434600.00	2424900.00	2424900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1947700.00	1947700.00	1939900.00	1939900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	486900.00	486900.00	484900.00	484900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4869200.00	4869200.00	4849800.00	4849800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15847000.00	14844000.00	14816200.00	14816125.00
210301	Гэрэл, цахилгаан	1250700.00	1248218.00	1224700.00	1224673.00
210302	Түлш, халаалт	14596300.00	13595782.00	13591500.00	13591452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22550400.00	19339000.00	15010100.00	15010100.00
210401	Бичиг хэрэг	3234400.00	2860600.00	2311500.00	1927000.00
210402	Тээвэр, шатахуун	17382300.00	14706400.00	11438500.00	12094200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1933700.00	1772000.00	1172100.00	900900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			88000.00	88000.00
2105	Нормативт зардал	500000.00	458300.00	957000.00	957000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500000.00	458300.00	957000.00	957000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2500000.00	15600.00	6535600.00	6535600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл			1150000.00	1150000.00
210604	Урсгал засвар	2500000.00	15600.00	5385600.00	5385600.00
2107	Томилолт, зочны зардал	1547300.00	2500600.00	1810300.00	1810300.00
210702	Дотоод албан томилолт	1547300.00	2500600.00	1810300.00	1810300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2150900.00	1784900.00	1286800.00	1286800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	684000.00	318000.00	150400.00	150400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	427600.00	427600.00	302200.00	302200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108300.00	108300.00	90300.00	90300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217900.00	217900.00	182900.00	182900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95600.00	95600.00	75000.00	75000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	478100.00	478100.00	379700.00	379700.00
210807	Газрын төлбөр	45600.00	45600.00	37300.00	37300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	93800.00	93800.00	69000.00	69000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600000.00	4388000.00	33620200.00	33620200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4388000.00	33120200.00	33120200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600000.00		500000.00	500000.00

13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	343822100.00	333449560.50	360703100.00	360703025.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	343822100.00	333449560.50	360703100.00	360703025.00
132001	Орон нутгийн төсвөөс	343822100.00	333449560.50	360703100.00	360703025.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				75.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	26.00	26.00	26.00
620001	Удирдах ажилтан	10.00	10.00	10.00	10.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	3.00	4.00	3.00
620004	Гэрээт ажилтан	3.00	4.00	3.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12605939.00	5701154.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12605939.00	5701154.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12605939.00	5701154.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1735511.00	0.00
210101	Үндсэн цалин	544000.00	
210104	Урамшуулал	1191511.00	
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	141325.00
210201	Тэтгэврийн даатгал		141325.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2200428.00	4021329.00
210401	Бичиг хэрэг	350000.00	105000.00
210402	Тээвэр, шатахуун	1504048.00	3916329.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	346380.00	
2107	Томилолт, зочны зардал	0.00	65000.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		65000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8670000.00	1473500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8670000.00	1473500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12605939.00	5701154.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12605939.00	5701154.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9700939.00	3101154.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2905000.00	2600000.00

3. Аудитын тайлан

3.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн №03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго нь “Иргэдэд төрийн үйлчилгээг тэгш, шуурхай үзүүлэх, төрийн хууль тогтоомж орон нутгийн засаг захиргааны байгууллагаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх, ажилчидын мэдлэг ур чадвар онцгойлон анхаарч ажиллах” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус сургуулийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2 хувиар буюу 7.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2055.5 сая төгрөгөөр буюу 1.5 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		75	
Авлага			
Бараа материал	48053.3	44773.8	-3279.5
Үндсэн хөрөнгө	1299314.4	3358091.0	2058776.6
Нийт хөрөнгө	1347367.8	3402864.9	2055497.1
Өр төлбөр	14133.5	4537.3	9596.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1333234.3	3398327.6	2065093.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1347367.8	3402864.9	2055497.1

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 75 төгрөгийн үлдэгдэлтэй, авлага данс оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 44.7 сая төгрөг болж 3.3 сая төгрөгөөр буурсаны дотор аж ахуйн материал 3.4 сая төгрөгөөр буурч, бичиг хэргийн зүйл 0.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд 23.5 сая төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байгаа боловч уг мал нь тус байгууллагад бодитоор байхгүй, малжуулах төслийн хүрээнд төсөлд хамрагдсан иргэдэд олгосон мал бөгөөд тухайн үед сумын Засаг даргын тамгын газарт орлогод авч бүртгэн үлдэгдлээр тайлагнаж ирсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”: 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2058.8 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан ба улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1851.6 сая төгрөгийн өртөг бүхий 2 км хатуу хучилттай авто зам, 253.9 сая төгрөгийн өртөг бүхий халуун усны барилга, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэгдсэн 5.7 сая төгрөгийн үнэ бүхий багийн Засаг дарга нарын мотоцикль, 8.8 сая төгрөгийн үнэтэй постын хөдөлгөөнт байр зэрэг нийтдээ 2150.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогод авч үндсэн хөрөнгөд 92.1 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дүнг тооллогын дүнтэй тулган шалгахад 2007-2013 оны хооронд хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зуслан, хаваржаа, намаржааны 6 чиглэлд хэрэгжсэн шороон замын засварын ажлыг төсөвт өртгийн дүнгээр 27.6 сая төгрөгөөр үнэлж данс бүртгэлд орлогод авч бүртгэсэн байна.

Энэ нь УСНББОУСтандарт 17, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.30-д заасан “Хүлээн зөвшөөрөлт”, 4.31 дэхь хэсэгт заасан “Үнэлгээ” заалтыг зөрчсөн байна.

Иймд тус байгууллагын санхүүгийн тайланд тусгагдсан 23.5 сая төгрөгийн бараа материал, 27.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, хуулийн зохих шаардлагыг хангахгүй байгаа тул учир шалтгааныг олж тогтоон зохих хууль журмын хүрээнд шийдвэрлэхийг зөвлөмж болгов.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4.5 сая төгрөг болж 9.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд ажилчидтай холбогдсон өглөг 3.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 6.5 сая төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2065.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2516.1 сая төгрөг байгаа ба тайлант онд 2149.7 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт хийгдсэн, 5.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон зэргээр өмнөх оноос орлого 2073.7 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос нийт дүнгээр 14.0 сая төгрөгөөр буурсан нь урьд оноос хангамж бараа материалын зардал 2.0 төгрөгөөр, бусад бараа үйлчилгээний зардлуудын өсөлт, бууралт нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Сагсай сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор 336.1 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор нийт зардлыг 24.6 сая төгрөгөөр нэмж тодотгон цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11.4 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 1.5 сая төгрөгөөр, нормативт зардлыг 0.5 сая төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 4.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 8.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, халаалтын зардлыг 1.5 сая төгрөгөөр хасаж тодотгон нийт төсвийг 360.7 сая төгрөгөөр баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 360.7 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 360.7 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 74.8 хувийг цалин, НДШ-ийн зардал, 4.1 хувийг тогтмол зардал, 4.1 хувийг хангамж бараа материалын зардал, 0.3 хувийг норматив зардал, 1.8 хувийг эд хогшил худалдан авах зардал, 0.5 томилолтын зардал, 9.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн давсан орлогоос 1.6 сая төгрөгийн, антений орлогоос 2.3 сая төгрөгийн, аймгийн Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 1.2 сая төгрөгийн, Гэр бүл, хүүхэд хамгаалах газраас 0.2 сая төгрөг, аймгийн ИТХ-аас 0.3 сая төгрөгийн, ТӨБЗГ-аас 0.1 сая төгрөгийн нийтдээ 5.7 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Мал тооллогын зардалд 1.2 сая төгрөг, ГБХЗХГ-т 0.2 сая төгрөг, хамтарсан багт 0.3 сая төгрөг, ОБХ-т тээврийн хөлсөнд 0.5 сая төгрөг, шар усны үерт 0.7 сая төгрөг, тендерийн бичиг баримтын зардалд 0.1 сая төгрөг, байгууллагын дотоод үйл ажиллагаанд 0.4 сая төгрөг, сэлбэг худааж авахад 1.4 сая төгрөг, үйлчилгээний хөлс болон бусад арга хэмжээнд 0.9 сая төгрөг тус тус зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сагсай сумын ЗДТГ-ын бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

ЗДТГазар нь гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 360.7 сая төгрөгийг зарцуулсан ба үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 311.6 сая төгрөгийн зардлыг хасахад 49.1 сая төгрөгийг тэвчиж болох зардал гэж үзээд Засгийн газрын тогтоолын дагуу уг зардлын 10 хувь болох **4.9 сая** төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д заасны дагуу 4.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй тул зөрчилд тооцон албан шаардлага өгөв.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Сагсай сумын ЗДТГ-ын 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 115 мэдээллийг хугацаандаа оруулсан, 3 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна.

Үүнд: 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр өглөг үүсгэсэн талаархи 14.0 сая төгрөгийн мэдээлэл болон 3 мэдээллийг хугацаа хожимдуулан байршуулсан байна. Шилэн дансны мэдээллийн хэрэгжилтийн дундаж хувь 80% -тай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлагатай холбоотой зөрчилд албан шаардлага өгөгдөж биелэлтийг хугацаандаа ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт илэрсэн 70.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд илэрч 4.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 65.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 4.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Сагсай сумын ЗДТГазар нь 360.7 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 49.1 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь 4.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэлт гаргаагүй 4.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Малжуулах төслийн хүрээнд сумын иргэдэд олгосон тус байгууллагад бодитоор байхгүй 23.5 сая төгрөгийн малыг бараа материалын дансанд бүртгэж ирсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”: 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “ үнэн зөв байх”, гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул учир шалтгааныг тогтоож зохих хууль журмын дагуу шийдвэрлэх.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 27.6 сая төгрөгийн өртөг бүхий зуслан, хаваржаа, намаржааны зам засварын 6 ажлыг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн байна.

2.2. Өгсөн зөвлөмж

УСНББОУСтандарт 17, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын “Үндсэн хөрөнгө” хэсгийн 4.30-д заасан “Хүлээн зөвшөөрөлт”, 4.31 дэхь хэсэгт заасан “Үнэлгээ” заалтуудыг үндэслэн 27.6 сая төгрөгийн зам засварын ажлыг данс бүртгэлээс хасах.

2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансанд 14.0 сая төгрөгийн өглөг үүссэн мэдээллийг оруулаагүй, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 80 хувьтай байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сагсай сумын ЗДТГазар	4	70.0					1	4.9	3	65.1